

## **НЭГ. “ӨСВӨР ҮЕ ХҮНС” ОНӨААТҮГ-ЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА**

### **1.1. “Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын хүний нөөцийн тэргүүлэх чиглэл**

“Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын одоо байгаа хүний нөөцийг хөгжүүлэх, ирээдүйн хэрэгцээ, шаардлагад нийцсэн хүний нөөцийг бүрдүүлэхэд уг хөтөлбөр, төлөвлөгөө, хүний нөөцийн бодлогыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана. Хүний нөөцийн тэргүүлэх чиглэл нь:

- “Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын Албан тушаалын тодорхойлолт /ажлын байрны тодорхойлолт/-д заасан чиг үүрэг, дүрэм журмаар хүлээсэн үүргийг бүрэн гүйцэтгэж чадах хүний нөөцийг бүрдүүлэх
- Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх
- Ажилтнуудын ухамсар, соёлыг дээшлүүлж, карьер хөгжлийн болон цалин хөлс, шагнал урамшууллын тогтолцоог ажлын бүтээмжийг дээшлүүлэх хөшүүрэг болгох
- Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар ажилтнуудыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах.

### **1.2. “Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын танилцуулга**

“Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 154 тоот тогтоолоор нийслэлийн Баянзүрх, Хан-Уул дүүргүүдэд үйл ажиллагаагаа явуулж байсан “Балчирхан”, “Хан-Уул Хангамж” НӨҮГ-уудыг нэгтгэснээр үүсэн байгуулагдсан. Бид 2022 онд нийслэлийн Баянзүрх, Хан-Уул дүүргүүдийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага буюу нийт 87 цэцэрлэг, 64 салбар цэцэрлэг, 14 сургуулийн 30000 орчим хүүхэд багачуудыг эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан, баталгаатай, чанартай хүнсний бараа бүтээгдэхүүнээр тасралтгүй хангах үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

Манай байгууллага нь 28 ажилтан албан хаагч, хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалтын 5 автомашин, бараа бүтээгдэхүүн хадгалах махны 1, хүнсний ногооны 1, хуурай хүнсний 6, нийт 8 агуулахын хүчин чадалтайгаар үйл ажиллагаагаа явуулж нийт 110 гаруй нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудыг ханган ажилладаг.

### **“Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын эрхэм зорилго**

Ханган нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг олшруулах, хүүхдийн насны онцлогт тохирсон илчлэг сайтай, шимт бодисын хэрэгцээ, витаминлаг байдлыг бүрэн хангасан хүнсээр хангах, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг цаашид дотоодын гарал, үүсэлтэй бүтээгдэхүүнээр бүрэн хангахад оршино.

### **“Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын зорилт**


Байгууллагын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, зардлыг хэмнэх үүднээс мал аж ахуй, газар тариалан зэргээр туслах аж ахуй эрхэлж үйл ажиллагааны цар хүрээгээ тэлэх.

### **1.3. “Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын хүний нөөцийн өнөөгийн байдал**

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1093 дугаар захирамжаар “Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын бүтэц, орон тооны хязгаарыг баталсан. Энэхүү бүтэц зохион байгуулалтаар “Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ нь 28 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.


## “ӨСВӨР ҮЕ ХҮНС” ОНӨААТҮГ-ЫН БҮТЭЦ

БАТЛАВ.  
“ӨСВӨР ҮЕ ХҮНС” ОНӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ Г.МӨНХЗҮЛ



- 2022 оны 12 дугаар сард хийсэн судалгаагаар “Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын ажилтнуудыг хүйсээр нь авч үзвэл:

График №01




Ажлын онцлог болон ачаалалтай холбогдон тус газарт 15 эрэгтэй ажиллагсад дийлэнх буюу 58 хувийг эзэлдэг. Ажил мэргэжлийн хувьд менежер, хүний нөөц, суурин нярав, жолооч, ачигч зэрэг ажлыг хийж гүйцэтгэж байна.

Эмэгтэй ажиллагсдын хувьд 13 буюу 42 хувийг эзэлж байгаа бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, нярав, тооцооны нягтлан бодогч, эрүүл ахуйч, бичиг хэрэг, архив касс, үйлчлэгч зэрэг албан тушаалуудад ажиллаж байна.

Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын ажилтнуудыг ажилласан жилээр нь авч үзвэл 6-15 жил ажилласан ажиллагсад 21 хувь, 79 хувь нь 1-5 жил ажилласан ажиллагсад байна.

**График 2**



Энэ нь дээрх шинэ ажиллагсдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, байгууллагын ажилтан болгон төлөвшүүлэх хэрэгцээ шаардлага байгааг илтгэнэ.

Байгууллагын нийт ажилтнуудын 54 хувь нь орон сууц болон түрээсийн байранд, 46 хувь нь гэр хороололд амьдардаг болох нь харагдаж байна.


График 3



Гэр хороололд амьдарч байгаа ажилтнуудыг нүүрс, түлээ олгох хөтөлбөрт хамруулан ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг ханган шийдэж өгөх нь зүйтэй.

Тус байгууллагад шаардлагатай хүний нөөцийн боловсролын төвшнийг харахад:

График 4



**ХОЁР. “ӨСВӨР ҮЕ ХҮНС” ОНӨААТҮГ-ЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ**

**2.1. Ажилтан, албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн нэгдүгээр зорилтын хүрээнд ажилтнуудын нийгмийн баталгааг хангах**

№	Хөтөлбөрийн зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Хугацаа	Тоо хэмжээ	Хариуцах ажилтан
1.	Ажиллах нөхцөл боломжоор хангах	Ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах тав тухтай орчинг бий болгохын тулд өрөө тасалгааны агааржуулалт, чийгшүүлэлт, гэрэлтүүлэг цэвэрлэгээний чанарыг дээшлүүлэх, цэцэгжүүлэх ажлыг зохион байгуулах мөн ажилтнуудын албан хэрэгцээнд тулгуурлан бичиг хэрэгсэл, шаардлагатай бусад материал, техник хэрэгслээр хангах;	Ажилтнуудын ажиллах нөхцөл бүрдэж, ажлын бүтээмж дээшилсэн байна.	Жилдээ	Тогтмол	Эрүүл ахуйч Бичиг хэрэг, архив, касс Үйлчлэгч
		Ажилтнуудын үдийн амралтын үеэр богино хугацаанд алжаал тайлах /цай, кофе уух, хөгжим сонсох, сонин сэтгүүл унших гэх мэт/ амрах өрөө, орчинтой байх нөхцлийг бүрдүүлэх	Ажилтнуудын үдийн амралтыг зөв боловсон өнгөрүүлэх таатай орчинг бүрдүүлсэн байна.	Жилдээ	Тогтмол	Хүний нөөц, ХАБ Эрүүл ахуйч
		Үйлчилгээний болон түгээлтийн ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл болон үйлчилгээнд шаардагдах хэрэгсэл, материалаар хангах;	Хүнстэй шууд харьцдаг ажилтнуудын эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал бүрэн хангагдсан байна.	Жилдээ	Тогтмол	Ерөнхий нягтлан бодогч Хүний нөөц,ХАБ Эрүүл ахуйч
2.	Ажилтнуудын цалин хөлс, нэмэгдэл, шагнал	Үндсэн цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх	Ажилтнуудын идэвхи нэмэгдэж, ажлын үр	Жилдээ	Тогтмол	Менежер Ерөнхий нягтлан бодогч

	урамшууллыг хууль тогтоомж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу олгох;	Байгууллагын ажилтнууд нь хариуцан ажиллаж буй чиг үүргийн хүрээнд мэргэжил дээшлүүлсэн тохиолдолд байгууллагын дотоод журмын дагуу тодорхой хэмжээний мөнгөн тэтгэмж олгох	дүн дээшилсэн байна.	Жилдээ	Тухай бүр нь	Ерөнхий нягтлан бодогч Тооцооны нягтлан бодогч
		Уралдаан, тэмцээнд оролцож амжилт гаргасан мөн ажлын үр дүнг үнэлсний үндсэн дээр шилдэг ажилтнаар шалгарсан ажилтныг байгууллагын дотоод журмыг үндэслэн байгууллагын захирлын тушаалаар шагнаж урамшуулах		Жилдээ	2 ажилтанд	Менежер Ерөнхий нягтлан бодогч
		Ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэн хагас жилд нэг удаа үр дүнгийн урамшуулалт цалинг захирлын дэргэдэх зөвлөлийн хурлаас гарсан саналыг үндэслэн захирлын шийдвэрээр олгох	Ажилтнуудын ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх замаар ажлын бүтээмж дээшилнэ.	Хагас жилд	1 удаа	Менежер Ерөнхий нягтлан бодогч
		Ажилтны хөдөлмөрийн амжилт, гавьяаг үнэлж төрийн шагнал, одон медалиар шагнуулах асуудлыг хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулах.	Ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмж, нийгэмд оруулсан хувь нэмрийг бодитоор үнэлнэ.	Жилд	Тухай бүр нь	Ерөнхий нягтлан бодогч Хүний нөөц, ХАБ
3.	Нийгмийн баталгааг хангах тусламж, дэмжлэг үзүүлэх	Ар гэрийн гачигдал, шинээр гэр бүл болох, шинээр хүүхэдтэй болоход санхүүгийн дэмжлэг, буцалтгүй тусламж үзүүлэх	Ажилтнуудад бодит тусламж болно.	Жилд	Тухай бүр нь	Менежер Ерөнхий нягтлан бодогч Хүний нөөц,ХАБ
		Гэр хороололд амьдардаг ажилтан албан хаагчдад жилд 1 удаа түлээ нүүрсний үнийн дүнгийн хөнгөлөлт олгох	Ажилтнуудын нийгмийн нэг баталгаа хангагдана.	Жилд	1 удаа	Менежер Ерөнхий нягтлан бодогч Хүний нөөц,ХАБ
		Албан хаагчдын 0-16 насны хүүхдүүдэд Хүүхдийн баяр, Шинэ жилийн баярыг тохиолдуулан баяр хүргэж бэлэг хүргүүлэх	Ажилтнууд болон гэр бүлийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх	Жилд	2 удаа	Ерөнхий нягтлан бодогч Хүний нөөц,ХАБ

		Байгууллагын ажилтан ажил, мэргэжлийн чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдах тохиолдолд ажил үүргийг зохицуулан, сургалтын төлбөрийн зохих хувийг захирлын тушаалаар тогтоож сурах бололцоог бүрдүүлж ажиллах	Ажилтнуудыг сургах боломж бололцоогоор ханган ажилласан байна.	Жилд	2-3 ажилтанд	Менежер Ерөнхий нягтлан бодогч
		Ахмадын өдрөөр өндөр настнуудыг хүлээн авах	Ахмад үеэ хүндэтгэх, залуу үеийг сургах	Жилд	1 удаа	Нийт албан хаагч
4.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах	Байгууллагын ажилтнуудад эрүүл мэндийн болон эрүүл аж төрөх ёсны мэдлэг боловсрол олгох.	Ажилтнууд эрүүл амьдрах зөв дадал, дуршилтай болно.	Жилд	2 удаа	Эрүүл ахуйч
		Байгууллагын нийт ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Ажилтнуудыг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, нийтлэг өвчлөлд онцгойлон анхаарна.	Жилд	2 удаа	Эрүүл ахуйч
		Бүх нийтийн цэвэрлэгээ, цэцэрлэгжүүлэлт, ногоон хөгжлийн арга хэмжээг зохион байгуулах	Эрүүл цэвэр орчныг бий болгох	Жилд	4-5 удаа	Хүний нөөц, ХАБ Эрүүл ахуйч
		Байгалийн үзэсгэлэнт газраар аялах, танин мэдэхүйн идэвхтэй амралт зохион байгуулах;	Байгалийн үзэсгэлэнт газартай танилцаж, түүхийг мэддэг болсон байна.	Жилд	1-2 удаа	Ерөнхий нягтлан бодогч Хүний нөөц, ХАБ
5.	Амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүнсний хангамжийг хариуцан ажилладаг дөрвөн байгууллагын дунд жил бүр зохион байгуулагддаг уламжлалт спортын уралдаан, тэмцээнд оролцох.	Дөрвөн байгууллагын хамт олны уур амьсгалыг сайжруулах	Жилд	1 удаа	Менежер Ерөнхий нягтлан бодогч Хүний нөөц, ХАБ

		Ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор 7 хоногт 1 удаа спорт заланд чөлөөт тоглолт явуулж байх;	Хамт олныг идэвхижүүлэх, эрүүл чийргээр чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх	Жилд	Тогтмол	Ерөнхий нягтлан бодогч Хүний нөөц, ХАБ



### **3.2. Ажилтан, албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хоёрдугаар зорилтын хүрээнд ажилтнуудыг сургалтаар хөгжүүлэх**

“Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын ажилтнуудын албан үүргээ хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, ур чадварыг тасралтгүй эзэмшүүлэх, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ажил хариуцах чадварыг сайжруулах замаар сургалтыг үе шаттайгаар явуулна.

Дээрх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- Ажилтнуудын сургалтын хөтөлбөр боловсруулж, батлуулах;
- Мэдлэг, чадвар, зан үйлийн сургалтыг тухай бүр зохион байгуулах;
- “Суралцагч” байгууллага болох зорилт тавих

### **3.3. Ажилтан, албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн гуравдугаар зорилтын хүрээнд Ажилтнуудыг ажлын байранд сонгох шалгаруулах**

"Өсвөр Үе Хүнс" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахад шаардлагатай орон тоонд мэргэшсэн чадварлаг боловсон хүчин сонгон шалгаруулж, ажлын байранд байршуулах, сул орон тоо гарсан тохиолдолд сул орон тооны зарыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлана. Мөн байгууллагын ажилтнуудаас уг ажлын байранд тохирох ажилтныг дэвшүүлж болно. Дээрх ажилтан нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үүргээ бүрэн биелүүлдэг
- Ажлын цаг ашиглалт сайн
- Олон нийтийн ажилд идэвхтэй оролцдог
- Сахилгын шийтгэлгүй

Дээрх шаардлагад нийцсэн ажилтныг сул ажлын байранд дэвшүүлэн ажиллуулах саналыг үндэслэн байгууллагын захирал шийдвэр гаргана. Шаардлагатай гэж үзвэл захирлын зөвлөлийн хурлаар асуудлыг хэлэлцүүлж болно.

### **3.4. Ажилтан, албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн дөрөвдүгээр зорилтын хүрээнд хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн сан бий болгох, ашиглах**

Ажилтнуудын хувийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэн хүний нөөцийн мэдээллийн санг бий болгож өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглана.

Шинээр ажилд томилогдохоос эхлээд тухайн ажилтны ажлаас чөлөөлөгдөх хүртэл бүх мэдээллийг багтаасан цаасан сан /хувийн хэрэг/-г ажилтан тус бүр дээр эрхлэн хөтлөх бөгөөд тухай бүр мэдээллийг баяжуулж товъёогжуулна. Ажилтны хувийн хэргийг хөтлөхдөө холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажиллана.

Дээрх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- “Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын цахим хүний нөөцийн мэдээллийн сан бүрдүүлэх
- Ажилд орох хүсэлт гаргасан иргэдийн мэдээлэл үүсгэх /online болон цаасаар хүсэлтийг хүлээн авах/
- Ажлаас чөлөөлөгдсөн ажилтны хувийн хэргийг архивлах

### **3.5. Ажилтан, албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн тавдугаар зорилтын хүрээнд Хүний нөөцийг эрсдэлийн удирдлагаар хангах**

Хүний нөөцийг эрсдэлийн удирдлагаар хангах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- Хүний нөөцийн хөтөлбөр, төлөвлөгөөний талаар ажиллагсдад таниулах
- Ажилтнуудыг сэлгэн, шилжүүлэн ажиллуулж ажлын байранд хөрвөх чадварыг бий болгох;
- Холбогдох хууль, дүрэм, журмын болон бусад сургалтыг тухай бүр зохион байгуулж ажилтнуудыг мэдээ, мэдээллээр хангах;
- Ажилтнуудад чиглэсэн цалин нэмэгдэл, болон бусад эдийн засгийн хөшүүргийг дэмжих;
- Ажилтнуудыг ажлын байранд тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
- Ажилтнуудыг мэргэшлээ дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;
- Ажил үүргийн давхардал, ажлын хэт их ачааллыг оновчтой хувиарлах;

### **3.6. Ажилтан, албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн зургадугаар зорилтын хүрээнд хүний нөөцийн ил тод байдлыг бүрдүүлэх**

Монгол Улсын Их Хурлын 2011 оны 06 дугаар сарын 16-ны өдөр баталсан “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулийн 6 дугаар

зүйлийн 6.1.2, 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 8.1.2, 8.1.3, 8.1.4, 8.1.5 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоолоор баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”-ыг тус тус үндэслэж “Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын хүний нөөцийн мэдээллийг байгууллагын цахим хуудсаар (childfood.ub.gov.mn) -ээр дамжуулан нийтэд мэдээлнэ.

Дээрх зорилтын хүрээнд дараах мэдээллийг ил тод байлгана.

- Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;
- Байгууллагын ажилтнуудын ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;
- Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсанд ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;
- Байгууллагын ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн чиглэлээр холбогдох мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулж шинэчлэх;
- Хууль тогтоомжид заасан бусад мэдээллийг мэдээлэх

## **ДӨРӨВ. АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

### **4.1. Ажилтан, албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн санхүүжилт**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

- “Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын тухайн жилийн үйл ажиллагааны зардалд төсөвлөсөн байна.

## **4.2. Хөтөлбөрийн хугацаа**

- Хөтөлбөрийг 2023-2026 онд жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлнэ.

## **4.3. Хэрэгжүүлэх арга зам**

- Хөтөлбөрийн хэрэгжилтийг үйл ажиллагааны алба, санхүү бүртгэлийн алба хариуцан гүйцэтгэнэ.
- Хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд жил бүр тусгаж ажиллана.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг жилээр дүгнэж, ажилтан, албан хаагчдад тайлагнана.

## **4.4. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих**

- Хөтөлбөрийн хэрэгжилтэд захирал, менежер, ерөнхий нягтлан бодогч нар хяналт тавин ажиллах

## **4.5. Ажилтан, албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хөтөлбөрийн үр дүн**

“Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ нь хүний нөөцийн нэгдсэн бодлого, төлөвлөлттэй явж ирснээр дараах үр дүн гарахаар тооцоолж байна. Үүнд:

- Ажилтнуудын дунд хамт олонч уур амьсгал, нэгэн зорилго чиглэлд чиглэсэн бүтээлч хандлага бий болно.
- Ажилтнуудын ажилдаа хандах хандлага сайжирч холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдана.
- Хүний нөөцийн хувиарлалт сайжирч боловсон хүчний мэргэшсэн байдал хангагдана.
- Ажилтнуудын мэдлэг, ур чадвар дээшилнэ.
- Ажилтнуудын мэдээллийн нэгдсэн сан бүхий бааз бүрдэж удирдлагын төвшинд шийдвэр гаргахдаа хүний нөөцийн мэдээ, мэдээлэлд тулгуурладаг чиг хандлага тогтоно.
- Байгууллагын эрхэм зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийн чадварлаг нөөц бүрдэнэ.